

Ө.Бадрахын мэндэлсний 115 жилийн ойд**Ө.БАДРАХ ТУВАГ МОНГОЛТОЙ НЭГТГЭХ БОДЛОГО,
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН НЬ***Г.Ариунболд**

1921 оны ардын хувьсгалын дараахан Монголын эрх баригчдын дунд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан Богдын засгийн газраас явуулж байсан монгол угсаат бусад овог аймгуудаа тухайлбал, Өвөрмонгол, Буриад, Барга, Тагна Урианхай зэрэг газрыг нэгтгэх гэсэн бодлого, үйл ажиллагааг үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэл нэлээд байлаа. Тухайлбал, С.Данзан, Б.Цэрэндорж зэрэг нам, төрийн зүтгэлтнүүд шинэ Монгол Улсад дагаар орох боломжтой нутаг бол Тагна Урианхай буюу тэр үед оросуудын нэрлэж байсан Урианхайн хязгаар гэж үзэж байв. Гэхдээ тухайн үед олон мянган орос иргэд нэгэнт суурьшсан болон тус хязгаар нутаг бүхэлдээ Зөвлөлт Оросын ивээлд багтаж байсны хувьд тагна тува нар Монголд нэгдэх асуудлыг хойд хөршийн эрх баригчдтай хэлэлцэн тохирох, мөн тува нарын өөрсдийн чин хүсэл эрмэлзэл зайлшгүй чухал гэдэг нь ойлгомжтой юм. Тагна Урианхайг Монголд нэгтгэхийн тулд юуны өмнө уг асуудлыг Москвад албан ёсоор тавихын зэрэгцээ урианхайн ард олны сэтгэл санааг тандан мэдэх, тува нарын Монголтой нэгдэх өргөдөл хүсэлтийг хүлээн авч, бүрэн эрхэт төлөөлөгчид томилон байдлыг газар дээр нь очиж судлах, нэгдэх асуудлыг зөв зохистой шийдэх талаар Монголын засгийн газрын байр суурийг ухуулан ойлгуулж, эв эеэр татах ажлыг идэвхитэй явуулж байв. Эл асуудал Монгол-Зөвлөлтийн харилцааны 1920-иод оны үеийн хамгийн эмзэг, хурц асуудлын нэг байсан бөгөөд коммунист дарангуйллын үед Тувагийн асуудлыг сөхөх, судлах, нийтлэхийг хагуу хориглосон тул монгол-зөвлөлтийн харилцааны түүхэн дэх “цагаан толбо” болон орхигдсон билээ.

Тагна Туваг Монгол улсад нэгтгэх үйл хэрэгт Өлзийтийн Бадрах хэмээх Баруун Монголын дөрвөд хөвгүүн өөрийн биеэр хүчин зүтгэж явсан тухай сонирхолтой баримт ОХУ-ын Холбооны Аюулгүй Байдлын Алба буюу ФСБ-гийн тусгай архивт хадгалагдан буй Ө.Бадрах¹-ын хавтаст хэргээс олдлоо.

Ө.Бадрахыг ЗХУ-ын нийслэл Москва хотод 1938 оны 2-р сарын 24-нд² НКВД буюу ЗХУ-ын Дотоод Хэргийн Ардын Комиссариатын Газрын мөрдөн байцаах үед “хувьсгалын эсэргүү байгууллага”-ын зүгээс Тувагийн үндсэрхэг үзэлтнүүдтэй хэр холбоотой, ямар агуулга зорилготой байсан талаар болон Тувад ямар ажлуудыг хийж байсан тухай асууж тодруулсан байна. Ө.Бадрах мөрдөн байцаалтанд хариулахдаа 5 зүйлийг мэдүүлжээ.

*Г.Ариунболд - БХИС-ийн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Нэгдүгээрт, “...Манай хувьсгалын эсэргүү байгууллагыг байгуулахын өмнө баруун хил хязгаарын нутагт би манай хувьсгалын эсэргүү байгууллагын удирдагчдын зааврын дагуу Ховдын цэргийн тойргийн ерөнхий жанжны тушаал ёсоор Тагна Тувагийн үндсэрхэг үзэлтнүүдтэй Туваг БНМАУ-тай нэгтгэх асуудлаар харилцаа тогтоон ажиллаж байсан.

Жишээ нь, 1924³ оны зун би өөрийн эх орондоо байх үедээ Ховдын цэргийн тойргийн захиргааны дөрвөдийн баруун аймгийн жанжин Давгын Гизэрт, урианхай хэл, зан заншил болон газар нутгийг мэддэг хүн явуулахыг тушаасан. Ховдын Цэргийн ерөнхий жанжин Гомбо-Идшин надад Ерөнхий сайд Цэрэндоржийн дараахи агуулга бүхүй нэгэн захиа үзүүлсэн юм. Уг захидалд, “Тагна Тувагийн хошуу болон сумдын хүн ам нь дотроо хоёр хэсэгт хуваагдсан байх агаад нэг хэсэг нь Тагна Туваг Монголтой нэгдэхийг хүссэн, харин нөгөө хэсэг нь биеэ даасан улс байгуулахыг хүссэн ажээ. Энэ үндсэн дээр тэнд овог аймгийн дайн явагдаж байна. Туваг Монголтой нэгтгэхийг хүссэн хэсгийг дэмжсэн талынхнаас манай засгийн газарт бүхэл бүтэн төлөөлөгчид ирүүлсэн байна. Та нар Ховдын цэргийн тойргийн штабаас энэ нь Тагна Туваг Монголтой нэгтгэхийг хүссэн, ямар хөдөлгөөн болохыг тогтоох тусгай хүнийг илгээнэ үү. ЗХУ болон Монгол Улсуудын засгийн газар асуудлыг шийдтэл энэ хөдөлгөөнүүд нь овог хоорондын дайн байлдааныг зогсоож байна уу хэмээн дамжуулна уу. Нэгэн зэрэг хүн амын дунд Тагна Тува болон Монголыг нэгтгэх үзэл санааг бататган бэхжүүлэх ажил явуулах хэрэгтэй” гэжээ.

Ховдын цэргийн тойргийн жанжин Гомбо-Идшин түүнд захиаг танилцуулсаны дараа хэлэхдээ, энэхүү захиа нь төв засгийн газрын заавар юм. Туваг Монголтой нэгтгэх үзэлтнүүдийн дунд энэ захианы дагуу үйл ажиллагаа явуулах хэргээр чи Тагна Тува явах зайлшгүй шаардлагатай байна. Явахынхаа өмнө чи манай хилийн цэргийн комиссар Дэмбэрэлтэй уулзах хэрэгтэй гэжээ. Үүний дагуу Ө.Бадрах хилийн цэргийн комиссар Дэмбэрэлтэй уулзсан бөгөөд түүнд Тагна Тува руу тийм ажлаар явах гэж байгаа тухайгаа хэлсэн байна. Энэ бол Бадрахын хувьд Дэмбэрэлтэй⁴ хийсэн хамгийн анхны уулзалт байсан юм.

Энэ тушаал болон зааврыг хүлээж аваад Ө.Бадрах “...Төгсбуянтын ... нарийн бичгийн дарга, мөн Буянт хошууны нарийн бичиг хийгээд шуудан зөөгч (өртөөчин)-гийн хамтаар тийшээ хөдөлсөн байна... Тагна Хүрээний төвд байх Буянбадрах⁵ хошуу болон Жамбаа бэйс хошууны төв хүрч, тэнд Буянбадрах хошуу захирагч, дахин байгуулагдсан Тагна Тувагийн Бүгд Найрамдах Улсын Дотоод Явдлын Яамны сайдаас огцорсон Нямжав тэргүүтэй, Бэйс хошууны захирагч Жамба, мөн Сангийн Яамны сайдаас огцорсон Шарав нарын зэрэг хүмүүс Халхтай нэгтгэх төлөвлөгөө зохиож байв.

Ө.Бадрах нар хошуу захирагч Буянбадрах, Тагна Тувагийн Бүгд Найрамдах Улсын Дотоод Явдлын Яамны сайдаас огцорсон Нямжав,

Бэйс хошууны захирагч Жамба, мөн Сангийн Яамны сайдаас огцорсон Шарав нартай танилцсаны дараа өөрийн хэрэг зорилгыг ярилцсан бөгөөд Ө.Бадрах, юуны өмнө овог аймаг хоорондын дайныг зогсоох хэрэгтэй хэмээн хэлээд, үүний хамтад тэднийг Монголтой нэгдэх гэсэн талаар тэдний санал бодлыг баталгах тайлбар зөвлөлтөө өгсөн юм. Бадрах хөдөө нутгаар явж, ардуудын санаа бодлыг судлан сонсчээ. Ер нь орон нутгийн ихэнх ардууд Монголтой нэгдэх сонирхолтой байв. Тэд Монгол нь энэ нэгтгэх асуудлыг хэзээ хэрэгжүүлэх гэж байгааг сонирхож байжээ.

Ө.Бадрах ойролцоогоор хоёр сар Тувад ажилласан. Энэ хугацаанд Бүрэн Эрхт төлөөлөгч Гомбо-Идшинтэй хэдэнтээ уулзаж байв.

Энэ хугацаанд Тагна Тувагийн ардуудын дотор БНМАУ-ын нам болон засгийн хамтын хэвлэл болох “Үндэсний Эрх” сонины №7-г тарааж байлаа. Энэ дугаарын хуудсууд нь Тагна Туваг Монголтой нэгтгэхийг дэмжсэн тухай ухуулгын өгүүлүүдээр дүүрэн байв. Үүний хамт дээрхи асуудалтай холбоотой сэдвээр ЗХУ-ын Гадаад Хэргийн Ардын Комиссар болон бүрэн эрхт төлөөлөгчтэй солилцсон захианууд мөн нийтлэгдсэн ажээ.

Ө.Бадрах энэ сонины тааралдсан дугааруудаас тусгаар тогтнолын тухай дурдсан хэсгийг авч хайчилбар хийж байв. Бадрыхыг тэнд ажиллаж байхад Тагна Тувагийн үндсэрхэг үзэлтэн Дондог, БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгч Бат-Очир болон ЗХУ-ын комиссынхон ирсэн бөгөөд тэд өөр хоорондоо танилцацгаасан. Дээр дурдсан Тувагийн үндсэрхэг үзэлтнүүдээс Нармандах, Санж нар БНМАУ-ын засгийн газарт Тувагийн бүрэн эрхт төлөөлөгч маягаар очиж уулзаж байсан. Бадрыхыг тэнд байхад буцаж очигцоосон бөгөөд Монголд очсон үр дүнгийн талаар тэд Бадрарахад ярьсан байв. Тэд “...Монголын засгийн газрын удирдагчид нэгдэхийг зөвшөөрч байсан ч гэсэн, ЗСБНХУ-ын засгийн газартай тохиролцох явцын хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэх болно хэмээн амласан, мөн Тува руу Хатанбаатарыг⁶ илгээсэн, удахгүй ирнэ” гэжээ. Үнэхээр ч Хатанбаатар, Бат-Очир, Магсар “Хурц”,⁷ буриад Гэлүн болон бас нэг хүн үүний дараахан удалгүй Тувагийн Бүгд Найрамдах Улсын нийслэл Кызылд ирсэн юм.

Ө.Бадрах Улаанбаатарт буцаж ирээд Сангийн Явдлын Яамны сайдаар ажиллаж байх үед дээр нэр дурдсан Дондог хоёр захиа ирүүлсэний нэг нь 1924 онд,⁸ нөгөө нь 1935 оны хавар,⁹ Бат-Очир хийгээд Ө.Бадрыхын нэрээр хаягласан байлаа. Эдгээр захианы агуулга: “Тагна Тува болон Монголыг нэгтгэх асуудал юу болж байна вэ? Та нар энэ асуудлыг шийдвэрлэхдээ заавал ч үгүй нэгдэх тал руу нь ашигтайгаар шийдвэрлэж өгөхийг ихэд хүсэмжилмой. Монголд хэвлэгддэг сэтгүүл ба номнуудыг ирүүлнэ үү”¹⁰ гэжээ. Ө.Бадрах хариу захиандаа, Тува болон Монголыг нэгтгэх асуудлаар манай засгийн газар ЗСБНХУ-тай хэлэлцээ хийж байгаа бөгөөд одоохондоо ямар нэг амжилт олоогүй байна хэмээн бичжээ. Үүний сацуу Ө.Бадрах намын сэтгүүлүүд болон бусад номнуудыг тэдэнд илгээжээ.

Тагна Туваг биеэ даасан улс хэмээн БНМАУ хүлээн зөвшөөрсөний дараа 1926 оны сүүлчээр Дондог Улаанбаатарт ирж, Монгол болон Тагна Тува Улсын хооронд найрамдлын гэрээ байгуулаад буцсан юм. Ө.Бадрах хөдөө албаны ажилтай явж байсан тул түүнтэй уулзаж чадаагүй бололтой.

Хоёрдугаарт, "...манай байгууллагыг байгуулагдахаас өмнө үндсэрхэг үзэлтнүүдийн нэг асан, хувьсгалын эсэргүү байгууллагын гишүүн Бэйл Аюурзана, БНМАУ-ын баруун хязгаарын үндэсний цөөнхийг Шинжаантай нэгтгэх зорилгоор Тувагийн үндсэрхэг үзэлтнүүд болох гүн Буянбадрах, Бэйс Жамба, захирагч Нямжав болон Шарав нартай уулзаж байжээ. Тийш байнга зорчих болж, Тагну Тувагийн Буянбадрахын болон Жамбын хошуунд "Түвдийн Цан Гэгээн сан" хэмээх жасыг эрхэлж байсан лам нар Табхай, Гончигшарав, Лосол болон хошуу захирагч ноёдууд хийгээд бусад хүмүүстэй харилцаатай байлаа.

Халх лам Табхай 1926 оныг хүртэл Аюурзана болон тувагийн үндсэрхэг үзэлтнүүдийн хооронд холбоочны үүргийг гүйцэтгэж байв. Тэд ах дүү шиг нөхөрлөх болж, түүгээр ч барахгүй дандаа л Улаангом болон Тувагийн хооронд зорчих болжээ. Миний бодож байгаагаар тэднээр дамжуулан холбоо барьж байсан болов уу" хэмээн Ө.Бадрах хэлсэн ажээ. Харин хэзээ ийм холбоо тогтоосон болон хэр үргэлжилсэнийг би мэдэхгүй гэжээ.

Гуравдугаарт; миний сонссоноор, Төгсбуянтын хүрээнд 1930 онд өдөөсөн хувьсгалын эсэргүү бослогын толгойлогч Хөөт Хараа Заланг Тагна Тува руу холбоо тогтоохоор илгээсэн. Энэ бүхэн нь манай баруун хязгаарын үндсэрхэг үзэлтнүүд болон тувагийн үндсэрхэг үзэлтнүүдийн хооронд харилцаа холбоо тогтсон байсныг батлах нэгэн баримт мөн.

Дөрөвдүгээрт; МАХН-ын Төв Хороо болон засгийн газар Тагна Тува руу Тагна Туваг Монголтой нэгтгэх байнгын ажлаар 1930 онд Доржпалам болон Найдансүрэн нарыг илгээсэн. Тэдний нэгийг нь намын бүрэн эрхт төлөөлөгчөөр томилж нөгөөхийг нь эвлэлийн бүрэн эрхт төлөөлөгчөөр томилсон бөгөөд тэдэнд онцгой удирдамж заавар өгчээ.

Энэ удирдамжийн үндсэн агуулга нь дараах зүйлд чиглэгдэж байсан: Тагну Тувагийн Ардын Намаар дамжуулан тувагийн ард олныг МАХН-тай нэгдэх хүсэл сонирхлыг нь өргөжүүлэн бататгах; Тувагийн Ардын Намыг МАХН-ын бүрэлдэхүүн хэсэг болгон хувиргах удирдамж өгчээ. Өөр хэд хэдэн зүйлийн заалтууд байсан бөгөөд үндсэндээ, бүгд иймэрхүү агуулгатай байсан, гэхдээ бүрэн тууштай биш байсан.¹¹

Тавдугаарт; би манай баруун байгууллагын¹² удирдагчид Лааган,¹³ Дадан, Жанчив, Цэнд болон бусад нөхдөд удирдамж чиглэл өгсөн байсан. Ялангуяа хилийн хоёр талд оршин суугаа дөрвөдийн ардууд болон тувагийн ардуудын хооронд найрамдлыг бататган

бэхжүүлэх, аж ахуйн харилцааг бататган бэхжүүлэх гэх мэт. Гэхдээ миний мэдэж буйгаар бол миний удирдамжуудыг хэрхэн хэрэгжүүлсэн хийгээд энэ ажлаас ямар үр дүнд хүрсэнийг, мөн түүнчлэн ямар хүмүүстэй харилцаа холбоо тогтоосон нь тодорхойгүй билээ.

Ө.Бадрах байцаалтын явцад Дөрвөд аймаг Монголоос салж Тагна Туватай нэгдэх хүсэлтэй байсан тухай зүйл бол худал цуурхал байсан хэмээн мэдүүлжээ. Тэрбээр, миний сонссоноор, 1927 онд Төгсбуянт Далай ханы хүү Жалсанноров нэгэн нөхрийг Тагна Тувагийн Житон (Чадан болов уу Г.А) хэмээх газарт илгээсэн, харин тэр худалдаачин нь Дөрвөд аймаг Тагна Туватай нэгдэх хүсэлтэй, түүнийг манай улсын нийслэлд амьдардаг Бадрах дэмжиж байгаа хэмээн цуурхал тарааж явсан юм гэжээ.

Дээр өгүүлсэн зүйлсийг нэгтгэн үзвэл дор дурдсан дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

1. Монгол Улсын эрх баригчдын дунд Тагна Туваг Монголтой нэгтгэх гэсэн байр суурь, үзэл бодол бодитой байсан бөгөөд Ө.Бадрах тэдгээрийг дэмжиж байв.

2. Бадрах Дөрвөдийн Зоригт хан хошуунд төрийн захиргааны алба залгуулж, суман занги байх үедээ хичээнгүй сайд Б.Цэрэндорж, Ховдын цэргийн тойргийн жанжин Гомбо-Идшингийн зааврын дагуу Тагна Тувад очиж, тэндэхийн хүн ам, нутаг орны байдлыг тандан судлах, суртал ухуулгын ажлыг зохион байгуулахад гар бие оролцож явсан байна.

3. Ө.Бадрахыг 1937 онд баривчлан ЗХУ-д аваачиж, эрүүдэн байцааж, хилсээр шийтгэхдээ Дөрвөд аймгийг тусгаар тогтноулах, Шинжаан эсвэл Тагна Туватай нэгтгэх зорилготой хувьсгалын эсэргүү байгууллагыг үүсгэн байгуулж, зохион байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн хэмээх ял зэм тулгах сонирхол байсныг энэхүү архивын баримт нотолж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Өлзийтийн Бадрах нь 1895 онд Ховдын хязгаарын Дөрвөдийн Сайн Заяатын баруун гарын чуулган Зоригт Чин вангийн хошуу, одоогийн Увс аймгийн Давст сумын нутаг Хандгайтын гол” хэмээх газарт төрсөн. Богд хаант Монгол Улсын үед хошууны тамгын бичээч, сумын занги, орлон хөөгч зэрэг алба хашиж байжээ. 1924-1934 онд Монгол Улсын Анхдугаар Их Хурлын дэд дарга, Улсын Бага хурал, МАХН-ын ТХ-ны гишүүнээр сонгогдож байв. 1924-1925 онд БНМАУ-ын Сангийн Хэрэг Эрхлэх Явдлын Яамны сайд, 1932 онд Ардын Эрүүлийг Хамгаалахын сайдаар томилогджээ. Мөн МАХН-ын ТХ-ны хэлтсийн эрхлэгч, нарийн бичгийн дарга, “Үнэн” сонины эрхлэгчээр ажиллаж байжээ. Монголын

Зохиолчдын Эвлэлийг санаачлан зохион байгуулагчдын нэг. 1934 онд “Лхүмбийн” хэмээх улс төрийн зохиомол хилс хэрэгт гүтгэгдэн ЗХУ-д цөлөгдсөн. Мөн Москва хотноо Коминтерний “Гадаадын ажилчин” хэвлэлийн газарт зөвлөхийн алба хашиж байв. 1937 оны 12-р сард улс төрийн хилс хэргээр баривчлагдан Москвад хүргэгдсэн бөгөөд 1941 онд ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулиар шийтгэгдэн, Лефортово дахь улс төрийн гянданд хоригдож байгаад буудуулсан хэмээн үздэг.

2. Специальный Архив ФСБ Российской Федерации., “Дело Улзийта Бадраха”. 89-90 дэх тал
3. 1924 оны зун буюу 6-7-р сард Ө.Бадрах одоогийн Увс аймаг буюу Дөрвөдийн Зоригт ханы хошуунд суман зангийн үүрэг гүйцэтгэж байсан. Харин Ө.Бадрах Б.Цэрэндоржийн даалгавраар Тува-д тусгай үүрэг хүлээн авч ажиллаж байсан нь тодорхой байна. (- Г.А.)
4. Энэ уулзалт нь Ө.Бадрахын Л.Дэмбэрэлтэй хийсэн анхны уулзалт байсан бөгөөд ингэж танилцсанаас хойш мөн Зүүнгарын хязгаар буюу Шинжаан Уйгарт Л.Дэмбэрэлтэй дахин хамтран ажиллаж байсан юм. (- Г.А.)
5. Буянбадрах хошуу хэмээсэн нь ноёны нэр болов уу. (- Г.А.)
6. Ө.Бадрах нь Хатанбаатар Магсаржавтай ийнхүү хоёр дахь удаагаа хамтарсан бөгөөд үүний урьд 1911 онд Манжийн ноёрхлын эсрэг Ховдыг чөлөөлөх түр цэрэгт Хатанбаатар Магсаржавын цэрэгт дайчлагдан цэрэг авч явсан байж болзошгүй түүхэн товч баримт Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архивт хадгалагдан буй. (- Г.А.)
7. Магсар “Хурц”-ын Дугаржав. (- Г.А.)
8. Специальный Архив ФСБ Российской Федерации., “Дело Улзийта Бадраха”., 89-90 дэх тал.
9. мөн тэнд
10. мөн тэнд
11. “Дело Джунгарского государства” или идея У.Бадраха о суверенитете западных монголов., Москвагийн оюутан магистрант, аспирантуудын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Москва. 2006.
12. Манай баруун байгууллагын гэдэг нь хожмын “Дөрвөдийг тусгаар тогтноулах баруун байгууллага” хэмээгдсэн бүлэг бололтой. (- Г.А.)
13. Улсын Бага Хурлын дарга асан Лааган. (- Г.А.)

**Специальный Архив ФСБ Российской Федерации.,
“Дело Улзийта Бадраха”. Москва – (1937-1941 гг).**

Протокол допроса
Обвиняемого Ульзуйто Бадархо от 24 . 2. 38 г.

Вопрос – В чем выражаясь связь вашей западной к/р организации с националистами Тувы и какая националистическая работа проводилась в Туве ?

Ответ : - До создания нашей к/р организация в западном пограничном районе я по указанию руководителей нашего к/р центра приказу главкома Кобдосского военного округа, устанавливал связь с националистами Танну-Тувы по делу объединения последней с МНР.

Например, в 1934 г. летом, когда я находился у себя на родине, главком Кобдосского военного округа западному дюрбетскому аймачному управлению Дагын-Гизер приказал отправить ему человека знающего урянхайский язык обычай и местность. Последний согласно этого приказа отправил меня и по приезде моем, главком Кобдосского военного округа Гомбо –Идшин мне показал одно письмо премьер министра Церендоржи следующего содержания :

“Население хошунов и сомонов Танну-Тувы раскололось на две части. Одна часть стоит за слияние Танну-Тувы с Монголией, а другая за создание самостоятельного государства. На почве этого у них идет междусобная война. Со стоорны группировки, стоящей за слияние с Тувы с Монголией приехала целая делегация к нашему правительству. Вам нужно из штаба главкома Кобдосского военного округа отправить специального человека с тем, чтобы он установил какое это движение, которое преследует цель слияния Танну –Тувы с Монголией. Не имеет ли это движение слияния Танну- Тувы с Монголией передайте, что нужно движение и междусобная войну прекратить без ущерба до разрешения вопроса между двумя правительствами СССР и Монголией. Одновременно с этим нужно вести работу среди населения по укреплению идеи слияния Танну-Тувы и Монголией”.

После того, как я познакомился с этим письмом, главком Кобдосского военного округа Гомбо-идшин , мне говорил :

“Данное письмо является указанием центрального правительства. Необходимо тебе поехать в Танну-Туву, где среди сторонников слияния Тувы с Монголией вести работу согласно этого письма. До поездки туда нужно тебе повидаться с нашим пограничным комиссаром т. Дембрыл”.

Согласно этого я виделся с пограничным комиссаром Дембрылом и рассказал ему, что я еду в Танну-Туву по такому то делу.

На это Дембрыл ответил: “Я надеюсь, что ты получил указание по линии нашей работы...” у меня лично...Больше он мне ничего не говорил, это была первая моя встреча с Дембрылом.

Получил эти установки и приказания, я вместе с секретарем Тугус-Буянту, хошуна Буянто и рассыльным (...) Бонго настал в центр Буян Бадархо да и Жимба беес хошунов, этот центр находился в Танно-хурене, оказалось, что там во главе с управляющим Буян-Бадархо да хошуном –Нимажабом, который был уволен с должности министра МВД, вновь созданный Танно-Тувинский республики и с управляющим Жимбо беес хошуном Шарапом, который был уволен с должности министра финансов Тувинской Республики, составлялся план слияния с Халхой.

Мы, познакомившись с ними, вели беседу в наших целях и я, в первую очередь, объяснил им, что не следует вести междуусобной войны и одновременно давал объяснения по укреплению их мнений относительно слияния с Монголией.

Я совершил поездки по худонским местностям, где изучал настроение арат. Оказалось, что все местные араты, где я побывал, имеют желание объединиться с Монголией. Они расспрашивали, когда Монголия намеревается осуществить это объединение.

Я работал там около двух месяцев. В это время лично был у полномочного представителя Гомбоидшина, которому положил ... вышеупомянутом.

В то время среди арат Танна-Тувинской республики широко распространилась газета “Үндэсний Эрхэ” №7 совместный орган партии и правительства МНР. Страницы этого номера все были наполнены агитационными статьями, одобряющими слияния Танну-Туву с Монголией.

Такие была помещена переписка с Наркоминделом СССР и полпредом, по данному вопросу. Я делал себе вырезки из попадавших мне в руки номеров этой газеты тех мест, где говорилось о независимости.

В те время, когда я работал там, прибыли Танна-Тувинский националист Дондок, представитель правительственной комиссии МНР Бато-Очир и правительственная комиссия СССР, с которыми и познакомился.

Из вышеупомянутых тувинских националистов Наран-Мандахо и Санжи, - ездили к правительству МНР, как уполномоченные. Они вернулись обратно, когда я находился там же, При нашей беседе о результатах их поездки, Они сообщили мне следующее :

Руководители монгольского правительства хотя и дали свое согласие на слияния, но одновременно обещали решить этот вопрос

по мере того, как договорятся с правительством СССР. Они отправили сюда Хотон –Батора, который скоро придет”.

И действительно вскоре после этого приехал Хатан-Батор, Бато-Очир, “Хурца” Максор, бурят Гелун и еще один человек, в столицу Тувинской Республики Кызыл.

После этого, когда я работал в Улан-Баторе Минфином, вышеупомянутый Дондок прислал две письма – одно в конце 1924 г., другое весной 1935 г. адресовав их на имя Бато-Очира и меня, содержание этих писем было таково :

“Как обстоит дело по вопросу и слиянии Танна-Тувы с Монголией. Прошу вас обязательно помочь при решении этого вопроса с тем, чтобы вопрос решился в пользу слияния. Пришлите журналы и книги издаваемые в Монголии”.

Я написал ответы на эти письма следующего содержания :

По вопросу слияния Тувы с Монголией, Наше правительство ведет переговоры с Советским Союзом, но пока нет результатов”.

Кроме того, я посылал партийные журналы и др. Книги. В 1926 г. после утверждения Танна-Тувы, как самостоятельной Республики, Дондок прибыл в Улан-Батор, где заключил договор о дружбе между Монголией и Танна-Тувой и вернулся обратно. В виду моей поездки в худон по служебным делам, я не сумел встретиться с ним.

Во –вторых ; я думаю, что член к /р центра Бэли-Аюурзана, который являлся одним из националистов, ставивших до создания нашей организации, Своей целью объединения национальных меньшинств Западного края МНР с Синыцзяном, имел связь с тувинскими националистами: гун-Буян-Бадархо, Бэйсэ-Жимба, захиракчи Нимажам и Шарап. Постоянно ездили туда, где имели связь с ламами Табхой, Гончик – Шарап, Лосол и др., которые управляли джасским, так назы ваемыми “Тибедин-Цан-Гегене-сан”, расположенными на территориях Буян-Бадархо и Жамба хошунов Танна-Тувы и ноенами управляющими хошунами.

Известно, что халхасцы лама Табхай до 1926 г., был связистом между Аюурзаном, и тувинскими националистами. Они сдружились, как братья. Мало того, они постоянно ездили между Уланкомом и Тувой. Поэтому я думаю, что через них осуществлялась связь.

До каких пор продолжалось такая связь – мне неизвестно.

В третьих, я слышал, что главаря к/р восстания, которое подняла наша западная к/р организация в 1930 г. в Тугусбуянту, хурена, отправили Хут-хара-Залана в Танна – Туву для установления связи. Это является подтверждающим фактом наличия связи между националистами нашего западного края и тувинскими националистами.

В-четвертом; ЦК МНРП и правительство отправили в Танна-Туву для усиленной и постоянной работы по слиянию Танна-Тувы с Монголией Доржи-Палама и Найдан –Суруна. Назначив одного из них партийный уполномоченным и другого уполномоченным ревсомола и доли им особые установки.

Основное содержание этих установок сводилось к следующему : через Танна-Тувинскому народную партию расширить и укрепить желания тувинских аратских масс объединиться с МНРП ; Тувинскую Народную партию превратить в составную часть МНРП. Ее было ряд пунктов, в основном такого же содержания, но не полно их последовательно.

В-пятых; я давал установки руководителям нашей западной организации Лагану, Дадану, Жанчибу, Цендэ и др. О необходимости проводить работу по укреплению дружбы между дюрбетским, аратами и тувинскими аратами, проживающих по обоим сторонам границы и такие по укреплению их хозяйственной связи. Но мне неизвестно, несколько помню они провели мои установки и каких результатов добились от этой работы, а также с какими лицами установили связь.

Был такой случай : я слышал, что в 1927 г. сын Тугус –Буянту Далай-хана-Жалсан Норбо отправил одного торговца в Танну-Туву в местность Житон, а этот торговец распространял слухи, что дюрбетский аймак желает слиться с Танно-Тувой, что одобрил Бодархо, который проживает в столице нашего государства.

Все эти связи и работы является деятельностью к/р центра на нашей западной организации, направленные на установление связи с тувинскими националистами по осуществлению своей цели мне известны остальные наши товарищи, работающие на местах – с какими лицами имели связь в Туве. ...”.

Показание много зачитано, правильность которого утверждаю своей подписью – Допрошенный Бадархо.

Допросил Галиндаб.

Верно.

Текст переведенного протокола допроса от 29/ II – 1938 года арестованного Ульзуйто Бадрахо объявил на монгольском языке переводчик следчасти 23 / 5 следчаст.

Балданов.